

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ


ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Я.АМАРЖАРГАЛ

НИЙЛҮҮЛЭГЧ

АРИУН ТОТУ ХХК-НИЙ
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Г.БУРМАА

ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ЛАБОРАТОРИЙН УРВАЛЖ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 225

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас Ариун Тоту ХХК (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь “W195/ Wondfo SARS-CoV-2 Antibody Test” шууд худалдан авах гэрээг (цаашид “бараа” гэх) 10,000,000(арван сая) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлнэ.
3. Захиалагч нь бараа нийлүүлэлтийн 800 ширхэг барааг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь доорх нэр төрлийн бараа бэлэн байгаа тул 2020 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.


Д/Д	Барааны нэр, төрөл	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
1	W195/ Wondfo SARS-CoV-2 Antibody Test	БНХАУ	Ширхэг	800	12,500	10,000,000
	Нийт дүн					10,000,000

5. Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.


ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга

 Н.Г.Гэрэлт-Од


Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

 Т.Бямбасүрэн


Эрүүл мэндийн яамны Эм, үйлдвэрлэл, технологийн газрын мэргэжилтэн

 А.Баярзаяа

Эрүүл мэндийн яамны Хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн

 Г.Бат-Эрдэнэ

Эрүүл мэндийн яамны ахлах нягтлан бодогч

 Г.Догсмаа

Эрүүл мэндийн яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн


 Д.Мөнхцэцэг

14210 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Олимпийн гудамж 2, Засгийн газрын VIII байр

Утас:263695

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Ариун Тоту ХХК-ийн нягтлан бодогч

 Р.Саранцэцэг

Ариун Тоту ХХК-ийн захирал

 Г.Бурмаа

